



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/208

Чойр

Цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улс байгуулагдсаны 815, 816, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Говьсүмбэр аймгийн баяр наадмын сурын харвааны эмэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байр эзэлсэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат Түвшингийн Маралмаад “Аймгийн Мэргэн” цол, дэд байр эзэлсэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат Насанбатын Энхзулд “Аймгийн Гарамгай харваач” цол, гутгаар байр эзэлсэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын харьяат Дамдинсүрэнгийн Оюунд “Аймгийн Гоц харваач” цол, дөтгөөр байр эзэлсэн Дундговь аймгийн Дэрэн сумын харьяат Өсөхжаргалын Бямбасүрэнд “Онч харваач” цол, тав дугаар байр эзэлсэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын харьяат Уртнасангийн Өлзийжаргалд “Тод харваач” цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ